**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 11 өдөр Дугаар А/512 Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны “Аймгийн 2022 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан батлах тухай” 7/02 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, 3 дугаар зүйлийн 3.3, аймгийн онцгой комиссын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдварын тархалтыг зогсоох, хариу арга хэмжээг зохион байгуулахаар ажилласан мэргэжлийн алба, албан хаагчдын ажиллагааны шатахуун, хоолны зардалд 56,812,767.00 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах нийт 56,812,767.00 төгрөг (тавин зургаан сая найман зуун арван хоёр мянга долоон зуун жаран долоо)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2022 оны батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

3. Тус санхүүжилтийг улсын онцгой комисст уламжлан зохих хууль тогтоомжийн дагуу эргэн төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), аймгийн онцгой комиссын орлогч, баруун бүсийн төв-Ховд аймгийн онцгой байдлын газрын дарга, хурандаа (Б.Алтанбадралт) нарт даалгасугай.

Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2572

Zah A/512 tum

Аймгийн Засаг даргын 2022 оны
08 дугаар сарын 11-ний өдрийн
А/512 дугаар захирамжийн хавсралт

## 2021-2022 ОНД СУМДАД ГАРСАН МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНИЙ ЗАРДЛЫН НЭГТГЭЛ

| Д\д | Сумдын нэр | Хугацаа | | Гүйцэтгэсэн даалгавар | Бусад зардал | | Нийт дүн | Е баримт бүрэн шивсэн | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эхэлсэн | дууссан | Гамшгийн төрөл | Тээвэр, шатахуун | Хоол | | Тээвэр, шатахуун | Хоол | Нийт дүн |
| 1 | Алтай | 2021.07.01 | 2021.12.31 | Малын Шүлхий өвчин | 2,852,850 | 490,000 | **3,342,850** | 2,852,850 | 490,000 | **3,342,850** |
| 2 | Булган | 2021.07.01 | 2021.12.31 | Малын Шүлхий өвчин | 19,995,940 | 8,255,250 | **28,251,190** | 19,995,940 | 8,255,250 | **28,251,190** |
| 3 | Үенч | 2021.07.01 | 2021.12.31 | Малын Шүлхий өвчин | 6,612,440 | 4,453,950 | **11,066,390** | | | - |
| 4 | Мөст | 2021.07.01 | 2021.12.31 | Малын Шүлхий өвчин | 7,164,300 | 5,950,000 | **13,114,300** | | 1,008,000 | **1,008,000** |
| 5 | Манхан | 2021.07.01 | 2021.12.31 | Малын Шүлхий өвчин | 4,990,000 | 4,589,300 | **9,579,300** | 4,990,000 | 3,981,200 | **8,971,200** |
| 6 | Мөнххайрхан | 2021.07.01 | 2021.12.31 | Малын Шүлхий өвчин | 4,565,000 | 1,750,000 | **6,315,000** | 2,685,000 | 380,400 | **3,065,400** |
| 7 | Дуут | 2021.07.01 | 2021.12.31 | Малын Шүлхий өвчин | 1,556,100 | 475,000 | **2,031,100** | | | - |
| 8 | Буянт | 2021.07.01 | 2021.12.31 | Малын Шүлхий өвчин | 2,765,271 | 1,761,900 | **4,527,171** | | | - |
| 9 | Жаргалант | 2021.07.01 | 2021.12.31 | Малын Шүлхий өвчин | 1,345,590 | 3,113,800 | **4,459,390** | | | - |
| 10 | Мянгад | 2021.07.01 | 2021.12.31 | Малын Шүлхий өвчин | 1,336,500 | 584,900 | **1,921,400** | 1,336,500 | 584,900 | **1,921,400** |
| 11 | Чандмань | 2021.12.31 | 2022.03.10 | Малын Шүлхий өвчин | 2,400,000 | 2,100,000 | **4,500,000** | 2,700,000 | 1,800,000 | **4,500,000** |
| 12 | Онцгой байдлын газар | 2021.08.09 | 2022.05.17 | Малын Шүлхий өвчин | 5,800,000 | 2,300,000 | **8,100,000** | 3,452,727 | 2,300,000 | **5,752,727** |
| **Нийт зардлын тооцоо 2021.07.01-2022.05.17ныг дуустал** | | | | | **61,383,991** | **35,824,100** | **97,208,091** | **38,013,017** | **18,799,750** | **56,812,767** |

-oOo-